

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР**



## НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**БУЛГАН АЙМГИЙН МСҮТ-ҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ ЖУРМЫН  
ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

*Хөдөлмөрийн зах зээлийн суурь судалгаагүйгээс мэргэжлийн боловсролыг  
иргэний сонирхол, хөдөлмөрлөх хэрэгцээнд тулгуурлан олгож байна.*

**АУДИТЫН КОД: БУА-2021/03/-ШТА-НА**

**БУЛГАН ХОТ 2021 ОН**

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор **Д.Анхбаяр**

Утас: 70342580

Цахим хаяг:

[Ankhubayard@audit.gov.mn](mailto:Ankhubayard@audit.gov.mn)

Аудитын менежер

**Ж.Энхцоодол**

Утас: 70342716

Цахим хаяг:

[Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)

Ахлах аудитор

**П.Содном**

Утас: 70342716

Цахим хаяг:

[Sodnomp@audit.gov.mn](mailto:Sodnomp@audit.gov.mn)

Аудитор

**З.Ганбаатар**

Утас: 70342716

Цахим хаяг:

[GanbaatarZ@audit.gov.mn](mailto:GanbaatarZ@audit.gov.mn)

**Энэхүү аудитын тайлантай холбоотой  
мэдээллийг дараах хаягаар авна уу.  
Цахим хуудас [www.audit.mn](http://www.audit.mn)**

**Аудитыг гүйцэтгэсэн:**

Булган аймаг дахь Төрийн  
аудитын газар

Дарга, Тэргүүлэх аудитор  
Д.Анхбаяр

Аудитын менежер  
Ж.Энхцоодол

Ахлах аудитор  
П.Содном

Аудитор  
З.Ганбаатар

Аудитын тайлан,  
дүгнэлттэй холбоотой  
асуудлаар нэмж  
тодруулах, асууж лавлах  
зүйл байвал 7034-2495  
дугаарын утсаар  
харилцана уу.

Аудитын тайланг УАГ-ын  
www. Audit.mn цахим  
хуудаснаас үзнэ үү.

**ХАЯГ:**

Булган аймгийн ЗДТГ  
нутгийн удирдлагын ордон  
403 тоот

Булган аймаг, Булган  
сум

2020 оны 12 дугаар сар

|                                                                     |     |
|---------------------------------------------------------------------|-----|
| Товчилсон үгийн тайлбар.....                                        | 2   |
| АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ<br>МЭДЭГДЭЛ..... | 3-4 |
| ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....                                               | 4   |

**БҮЛЭГ 1. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТЫН  
ОРЧИН БҮРДСЭН, БОЛОВСОН ХҮЧНЭЭР ХАНГАГДСАН, БАГШ  
НАР ХУУЛЬД ЗААСАН ШАЛГУУРЫГ ХАНГАЖ БАЙНА.**

|                                                                                                |     |
|------------------------------------------------------------------------------------------------|-----|
| 1.1.1 Мэргэжлийн боловсрол, сургалтыг олгох багшлах<br>боловсон хүчнээр хангагдсан байна. .... | 4   |
| 1.1.2 Сургалт явуулах орчин, тоног төхөөрөмж хүрэлцээ<br>хангалттай байна. ....                | 5-6 |
| 1.2 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас зориулалт<br>бус зарцуулсан байна.....          | 8-9 |

**БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ СУДАЛГАА  
ХИЙГДЭЭГҮЙ НЬ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫГ ЭРЭЛТТЭЙ  
МЭРГЭЖЛЭЭР ОЛГОЖ ЧАДАЖ БАЙГААГ ТОДОРХОЙЛОХ  
БОЛОМЖГҮЙ НӨХЦӨЛ БАЙДАЛД ХҮРГЭЖ БАЙНА.**

|                                                                                                                                                                                 |       |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------|
| 2.1.1 Мэргэжлийн боловсрол олгох байгууллага нь зөвхөн<br>суралцагчийн хэрэгцээ сонирхолд үндэслэн элсэлтийг зохион<br>байгуулжээ.....                                          | 10-14 |
| 2.1.2 Мэргэжлийн боловсрол олгох чиглэлийг бүрэн<br>хэрэгжүүлээгүй, аймгийн хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй<br>мэргэжил олгож байгаа эсэхийг тодорхойлох боломжгүй<br>байна..... | 15-17 |
| 2.2.1 Булган аймаг дахь МСҮТ -үүдэд дотоод хяналт, шалгалт<br>нь үр дүн, үр нөлөөгүй байна.....                                                                                 | 17-19 |
| Дүгнэлт.....                                                                                                                                                                    | 19    |
| Зөвлөмж.....                                                                                                                                                                    | 19    |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

|         |                                                 |
|---------|-------------------------------------------------|
| ХНХЯ    | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам               |
| ХХҮГ    | Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар             |
| АЗДТГ   | Аймгийн Засаг даргын тамгын газар               |
| ААНБ    | Аж ахуй нэгж байгууллага                        |
| МБСҮЗ   | Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл |
| МСҮТ    | Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв             |
| ХААМСҮТ | Хөдөө аж ахуйн Мэргэжил сургалтын төв           |

## **АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**

### **Аудит хийсэн үндэслэл:**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.6-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын их хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаал баталсан “Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Булган аймгийн МСҮТ-үүдийн үйл ажиллагаа, хууль, журмын хэрэгжилтийн үр дүнд нийцлийн аудит хийлээ.

### **Аудитын зорилт:**

Аймгийн МСҮТ-үүдийн үйл ажиллагаа, хууль, журмын хэрэгжилтийн үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- ✓ Сургалтын хэрэгцээ шаардлагыг хангахуйц бүтэц, хөрөнгө, хүний нөөц хангагдсан эсэх;
- ✓ Мэргэжлийн боловсрол олгох зорилго, зорилтоо хууль журамд нийцүүлэн хэрэгжүүлж байгаа эсэх.

### **Аудитын хамарсан хүрээ:**

Аудитад аймгийн МСҮТ-үүдийн 2020 оны үйл ажиллагааны мэдээлэл, тайлан, тоон өгөгдөл болон бусад нотлох баримтад үндэслэн дүн шинжилгээ хийж аудитыг гүйцэтгэсэн болно.

Тус аудитад аймаг дахь МСҮТ, ХААМСҮТ-үүдийн холбогдох мэргэжилтнүүдийн 2020-2021 оны хичээлийн жилийн хугацааны үйл ажиллагааг хамруулж, анхан шатны баримт материалыг түүвэрлэн аудит хийлээ.

### **Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 400, 3000-3100, 5400-5499, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан асуудал эрхэлсэн байгууллага, холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, тайланг судалж, нотлох зүйлсийг шалгуур үзүүлэлттэй харьцуулан нягтлан шалгах, харьцуулалт, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, цахим сангаар иргэд, олон нийтээс асуулга авах, үнэлэх зэрэг арга зүйг ашиглав.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүйн дагуу хэрэгжүүлсэн горим, сорилыг үнэлж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад дараах хууль эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль,
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль,
- Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хууль,
- ЗГ-ын 2016 оны 304 дүгээр тогтоолоор батлагдсан "Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр",

- Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого",
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар авах арга хэмжээний тухай",
- Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолоор баталсан "Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах түүнд хяналт тавих журам",
- ХНХС-ын 2019 А/187 дугаар тушаалаар батлагдсан "Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журам",
- Хөдөлмөрийн сайдын сайд, боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын А/171, А/496 дугаар тушаалаар батлагдсан "Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам",
- Засгийн газрын 2016 оны 290 дүгээр тогтоолоор батлагдсан "Мэргэжлийн боловсрол сургалтын үндэсний зөвлөлийн дүрэм",
- Мэргэжлийн боловсрол сургалт, ерөнхий шаардлагын стандарт

### Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол хэрэгжүүлж, ахлах аудитор П.Содном, аудитор З.Ганбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

### ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аймаг дахь Мэргэжил сургалт үйлдвэрийн төв нь 2019-2020 оны хичээлийн жилд 61 орон тоотой үүнээс 25 багш 16 чиглэлээр, ХАА-н Мэргэжил сургалт үйлдвэрийн төв 41 орон тоотой 11 багш 9 чиглэлээр тус тус сургалтын үйл ажиллагаа явуулж нийт 1 жилийн 366, 2.5 жилийн 45 хүүхэд төгсгөж хөдөлмөрийн зах зээлд нийлүүлжээ.

Аймаг дахь МСҮТ нь 1 жилийн сургалтанд 12 мэргэжилээр 288, 2.5 жил сургалтанд 4 мэргэжлээр 40 суралцагч, ХАА-н МСҮТ-д 2019-2020 оны хичээлийн жилд 2.5 жилийн сургалтад 1 мэргэжлээр 8 суралцагч, 1 жилийн сургалтад 9 мэргэжлээр 141 суралцагч элсүүлж сургалтын үйл ажиллагаа явуулжээ.

## БҮЛЭГ 1. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТЫН ОРЧИН, БОЛОВСОН ХҮЧНЭЭР ХАНГАГДСАН БАЙНА.

### 1.1.1 Мэргэжлийн боловсрол, сургалтыг олгох боловсон хүчнээр хангагдсан байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/21 тоот тушаалаар орон тооны хязгаарыг аймаг дахь МСҮТ-ийг 61, ХААМСҮТ-ийг 41 орон тоотой байхаар баталжээ. Үүнээс багшийн орон тоог аймаг дахь МСҮТ-ийн хувьд 26, ХААМСҮТ-ийг 15 орон тоотой баталжээ.

Аймгийн МСҮТ-үүдийн орон тооны хязгаар болон гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал

|                  |                           | /Хүснэгт 1/   |           |                 |           |
|------------------|---------------------------|---------------|-----------|-----------------|-----------|
| №                | Албан тушаал              | Аймаг ХААМСҮТ |           | Аймаг дахь МСҮТ |           |
|                  |                           | Төлөвлөгөө    | Гүйцэтгэл | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл |
| Захиргаа аж ахуй |                           |               |           |                 |           |
| 1                | Захирал                   | 1             | 1         | 1               | 1         |
| 2                | Захиргаа аж ахуйн менежер |               |           | 1               | 1         |
| 3                | ХН ГХХ ажилтан            | 1             | 1         | 1               | 1         |
| 4                | ХШ МХА мэргэжилтэн        | 1             | 1         | 1               | 1         |

|                       |                                       |           |           |           |           |
|-----------------------|---------------------------------------|-----------|-----------|-----------|-----------|
| 5                     | Ерөнхий нягтлан бодогч                | 1         | 1         | 1         | 1         |
| 6                     | ХАБЭА ажилтан                         | 1         | 1         | 1         | 1         |
| 7                     | Захирлын туслах, бичиг хэрэг архив    | 1         | 1         | 1         | 1         |
| 8                     | Нярав                                 | 1         | 1         | 1         | 1         |
| 9                     | Дотуур байрны тогооч                  | 2         | 2         | 1         | 1         |
| 10                    | Тогоочийн туслах                      |           |           | 2         | 1         |
| 11                    | Сахиул                                | 1         | 1         | 1         | 3         |
| 12                    | Жижүүр                                |           |           | 3         | 1         |
| 13                    | Үйлчлэгч                              | 1         | 1         | 6         | 6         |
| 14                    | Жолооч                                | 1         | 1         | 1         |           |
| 15                    | Слесарь цахилгааны ажилтан            | 1         | 1         | 1         |           |
| 16                    | Мужаан                                |           |           | 1         | 1         |
| 17                    | Галч                                  | 4         | 5         |           |           |
| <b>Сургалтын алба</b> |                                       |           |           |           |           |
| 18                    | Сургалтын менежер                     | 1         | 1         | 1         | 1         |
| 19                    | Сургалтын албаны арга зүйч            | 1         | 1         | 1         | 1         |
| 20                    | Багш 15                               | 15        | 11        | 26        | 25        |
| 21                    | Нийгмийн ажилтан                      |           |           | 1         | 1         |
| 22                    | НТ, ХЗЗСС статистик хариуцсан ажилтан | 1         | 1         | 1         | 1         |
| 23                    | ЦТТ, МССХ хариуцсан мэргэжилтэн       | 1         | 1         | 1         | 1         |
| 24                    | Сургуулийн эмч                        | 1         |           | 1         | 1         |
| 25                    | Дотуур байрны багш                    | 3         | 3         | 4         | 3         |
| 26                    | Номын санч                            | 1         | 1         | 1         |           |
|                       | <b>Нийт дүн</b>                       | <b>41</b> | <b>37</b> | <b>61</b> | <b>55</b> |

Эх сурвалж: ХНХ сайдын 2017 оны А/21 дугаар тушаал

Хүснэгтээс үзэхэд Булган аймгийн ХАА-н МСҮТ 2020 оны 4 дүгээр сар хүртэл галч 1 илүү ажиллаж байсныг слесарь, цахилгаанчин ажлаас чөлөөлөгдсөнөөр тус ажилд шилжүүлэн ажиллуулсан, анги дүүргэлт, элсэлтээс шалтгаалан ерөнхий эрдмийн 4 хичээлд цагийн багш авч ажиллуулсан, сургуулийн эмчийн сул ажлын байранд Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий эмчтэй болох албан шаардлага өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Аймаг дахь МСҮТ**-ийн хувьд слесарь цахилгаанчин, номын санчийн орон тоонд хүн авч ажиллуулаагүй, жолоочийн орон тоо дутууг сахиул хавсран гүйцэтгэж байна. Бусад орон тооны хувьд батлагдсан орон тооноос тогоочийн туслах 1, жижүүр 2, дотуур байрны багш 1 дутуу байгаа бол сахиул 2 илүү ажиллаж байгаа нь аймгийн МСҮТ-үүд нь ХНХС-ын баталсан бүтэц, орон тооны тушаалыг баримталж ажиллаагүй байна.

### 1.1.2 СУРГАЛТ ЯВУУЛАХ ОРЧИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХҮРЭЛЦЭЭ ХАНГАЛТТАЙ Ч ЗАРИМ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ОНОЛЫН БОЛОН ДАДЛАГЫН БАЙР СТАНДАРТАД ЗААСАН ХЭМЖЭЭНД ХҮРЭХГҮЙ БАЙНА.

Аймаг дахь ХААМСҮТ нь 2 ээлжээр хичээллэх боломжтой хичээлийн 7, дадлагын 10 байртай бөгөөд хичээлийн байранд номын сан, спорт заалтай харин

дээрх стандартад заагдсан лаборатори, соёлын танхим байхгүй байгаа нь MNS 6541:2015 стандартын 10.2<sup>1</sup> -д заасан заалттай нийцэхгүй байна.

ХААМСҮТ нь 2020-2021 оны хичээлийн жилд нийт 7 онолын танхим, 10 дадлагын газарт үйл ажиллагаа явуулсан бөгөөд онолын танхим нийт 444.5 м.кв, дадлагын газар нийт 32518 м.кв талбайтай байна.

Дээрх стандартын 10.5-д “Сургалтын онолын танхимын нэг суралцагчид ногдох хэмжээ 2 м.кв-аас багагүй байна” гэж заасан байна.

**ХААМСҮТ-ийн 2020-2021 онд суралцаж буй оюутан нэг сурагчид  
ногдох талбайн хэмжээ**

/Хүснэгт №2/

*Эх сурвалж: Барилгын зураг, байгууллагын даргын сурагч элсүүлэх тухай тушаал*

| №  | Сургалтын нэр<br>мэргэжил/чадамж           | Онолын<br>танхим<br>дугаар | Метр<br>квадрат | хүчин чадал<br>/суралцагчийн<br>тоо/ | Суралца<br>г-чийн<br>тоо | Дадлагын<br>газрын<br>талбайн<br>хэмжээ |
|----|--------------------------------------------|----------------------------|-----------------|--------------------------------------|--------------------------|-----------------------------------------|
| 1  | Сүү боловсруулах<br>үйлдвэрийн ажилтан 2.5 | 208                        | 36              | 18                                   | 8                        | 54                                      |
| 2  | Сүү боловсруулах<br>үйлдвэрийн ажилтан 1   | 208                        | 36              | 18                                   | 15                       | 54                                      |
| 3  | Сүү боловсруулах<br>үйлдвэрийн ажилтан     | 201                        | 47.8            | 24                                   | 15                       | 54                                      |
| 4  | Малын асаргаа 2.5                          | 206                        | 22.3            | 11                                   | 7                        | 20                                      |
| 5  | Малын асаргаа 2.5                          | 206                        | 22.3            | 11                                   | 6                        | 25                                      |
| 6  | Малын асаргаа 2.5                          | 205                        | 22.4            | 11                                   | 7                        | 54                                      |
| 7  | Малын асаргаа 1                            | 205                        | 22.4            | 11                                   | 14                       | 25                                      |
| 8  | Тракторын механик 1                        | 105                        | 46.7            | 23                                   | 13                       | 72                                      |
| 9  | Жимс, жимсгэнийн аж<br>ахуйн фермер 1      | 204                        | 22.3            | 11                                   | 14                       | 20000                                   |
| 10 | Хүлэмжийн аж ахуйн<br>фермер 1             | 106                        | 39.5            | 20                                   | 15                       | 160                                     |
| 11 | Хүнсний ногооны<br>фермер 1                | 106                        | 39.5            | 20                                   | 15                       | 5000                                    |
| 12 | Ойжуулагч 1                                | 201                        | 47.8            | 24                                   | 11                       | 7000                                    |
| 13 | Зөгийчин зөгийн аж<br>ахуйн эрхлэгч 1      | 106                        | 39.5            | 20                                   | 15                       | 00                                      |
| 14 | Нийт дүн                                   |                            | 444.5           | 203                                  | 155                      | 32518                                   |

Хүснэгтээс харахад 2020-2021 оны хичээлийн жилд малын асаргаа, жимс, жимсгэнийн аж ахуйн фермерийн ангиуд нь дээрх стандартад заасан нэг суралцагчид ногдох талбай хэмжээ 2 м.кв-аас багагүй гэсэн заалттай нийцээгүй байна.

Харин дадлагын байрны талбайн хэмжээ нь бүгд 40 м.кв-аас дээш байгаа нь мэргэжлийн онцлог, шаардагдах техник, тоног төхөөрөмжийн овор хэмжээнээс хамаардаг тул стандартын шаардлагыг бүрэн хангаж байна.

**Аймаг дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв**

Аймаг дахь МСҮТ-ийн хичээлийн байранд 2020-2021 оны хичээлийн жилд 12 онолын танхим, 12 дадлагын газарт үйл ажиллагаа явуулсан бөгөөд онолын танхим нийт 644.8 м.кв, дадлагын газар нийт 840.2 м.кв талбайтай байна.

<sup>1</sup> 10.2 “мэргэжил тус бүрээр сургалтын онолын танхим, дадлагын газар болон лабораторийг байгуулж, шаардагдах тоног төхөөрөмжийг суурилуулан гар багаж хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн

Аймаг дахь МСҮТ-ийн 2020-2021 онд суралцаж буй оюутан нэг сурагчид  
ногдох талбайн хэмжээ

/Хүснэгт №3/

| №               | Сургалтын нэр<br>мэргэжил/чадамж                 | Онолын<br>танхим<br>дугаар | Метр<br>квадрат | хүчин<br>чадал | Суралцаг<br>чийн тоо | Дадлагын<br>газрын талбайн<br>хэмжээ |
|-----------------|--------------------------------------------------|----------------------------|-----------------|----------------|----------------------|--------------------------------------|
| 1               | Тогооч                                           | 113                        | 46.7            | 23.4           | 39                   | 110                                  |
| 2               | Оёмол<br>бүтээгдэхүүний<br>оёдолчин              | 2-р байр                   | 74.7            | 37.4           | 37                   | 44                                   |
| 3               | Авто машины<br>засварчин                         | 1-байр                     | 72              | 36             | 18                   | 114                                  |
| 4               | Барилгын засал<br>чимэглэлч                      | 3-р байр                   | 65              | 32.5           | 16                   | 68.5                                 |
| 5               | Тракторын механик                                | 114                        | 46.7            | 23.4           | 17                   | 114                                  |
| 6               | Гагнуурчин                                       | 3-р байр                   | 64.5            | 32.3           | 19                   | 64.5                                 |
| 7               | Нарийн бичгийн<br>дарга албан хэргийн<br>ажилтан | 217                        | 48.9            | 24.5           | 36                   | 48.9                                 |
| 8               | Цахим тоног<br>төхөөрөмжийн<br>ажилтан           | 218                        | 47.8            | 23.9           | 20                   | 47.8                                 |
| 9               | Гоо засалч                                       | 110                        | 32              | 16             | 22                   | 86                                   |
| 10              | Үсчин                                            | 109                        | 32              | 16             | 25                   | 30                                   |
| 11              | Модон эдлэлийн<br>мужаан                         | 2-р байр                   | 82.5            | 41.3           | 17                   | 82.5                                 |
| 12              | Бэлэг дурсгалын<br>зүйл урлаач                   | 2-р байр                   | 32              | 16             | 19                   | 30                                   |
| <b>Нийт дүн</b> |                                                  |                            | 644.8           | 322.4          | 285                  | 840.2                                |

Эх сурвалж МСҮТ-ийн барилгын зураг, байгууллагын даргын сурагч элсүүлэх тухай тушаал

Хүснэгтээс харахад 2020 онд 1 суралцагчид ногдох онолын танхимын талбайн стандартыг бэлэг дурсгалын зүйл урлаач, гоо засалч, үсчний ангиуд харин дадлагын байрны стандарт бэлэг дурсгалын зүйл урлаач, үсчний ангиудаас бусад мэргэжлийн ангиуд хангагдаж байна.

2020-2021 оны хичээлийн жилд аймаг дахь МСҮТ-д 3 төрлийн 14,015.0, ХААМСҮТ-д 24 төрлийн 239,378.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж багаж хэрэгсэл тус тус нийлүүлэгдсэнээр мэргэжлийн ангиудын багаж хэрэгслийн хүрэлцээ хангамж сайжирсан байна.

Стандартчиллын үндэсний зөвлөлийн баталсан MNS 6541:2015 стандартад заасан маягтын дагуу тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсалтыг сургалтын танхим, дадлагын газар тус бүрээр хөтлөөгүй зөрчилд албан шаардлага өглөө.

Хичээлийн жилд аймаг дахь МСҮТ-д ерөнхий боловсролын сурах бичиг 18, мэргэжлийн боловсролын 3, ХААМСҮТ-д 24 төрлийн 1,774.6 мянган төгрөгийн ерөнхий боловсролын сурах бичгийг нэмэгдсэн байгаа нь сурах бичгийн хүрэлцээ, хангамж сайжирсан байна.

Мэргэжил сургалт үйлдвэрийн төвүүдийн багш нарт зөөврийн компьютер, анги танхимд суурин компьютер хүрэлцээтэй, зарим дадлагын байр сүүлийн үеийн шинэ тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан зэргээс үзэхэд сургалтын орчны хүрэлцээ хангамж бүрдсэн байна.

## 1.2 ХИЧЭЭЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДАДЛАГА ХИЙХ ЗАРДЛААС ЗОРИУЛАЛТЫН БУС ЗАРЦУУЛСАН БАЙНА.

Аймаг дахь ХААМСҮТ нь 2020 онд 652399.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 649399.6 мянган төгрөгийг улсын төсвөөс 3000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр 637852.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 2700.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж ажилласан байна. Урсгал үйл ажиллагаанд 554982.1 мянган төгрөгийг зарцуулж 85870.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Байгууллагын батлагдсан төсөв гүйцэтгэлийг графикаар харуулбал  
Дүрслэл № 1



Батлагдсан төсвөөс 85870.3 мянган төгрөг буюу 13.4 хувиар хэмнэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын бүлгийн дүнгээр нь шинжилж үзэхэд цалин хөлс болон нэмэгдэл урамшил 62802.8 буюу 12.9 хувь, байр ашиглалтын зардал 276.8 мянган төгрөг буюу 0.8 хувь, норматив зардал 6585.1 мянган төгрөг буюу 36.4 хувиар тус тус хэмнэж, бусад зардлын хувьд батлагдсан төсвийн хэмжээнд зарцуулсан байна.

Батлагдсан урсгал зардлаас хэмнэгдсэн шалтгааныг судалж үзэхэд цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл нь орон тоо дутуу, норматив зардлын хэмнэлт нь ковид-19 өвчин гарсантай холбоотой сургалтын үйл ажиллагаа зогссонтой холбоотой хоолны зардал байна.

Аудитаар хичээлийн үйлдвэрлэлийн зардлыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж байгаа эсэхийг үзлээ.

Хичээл үйлдвэрлэлийн зардлыг эдийн засгийн ангилал батлах тухай Сангийн сайдын 2014 оны 55<sup>2</sup> дугаар тушаалаар баталсан байна.

<sup>2</sup> "Төсөвт байгууллагын албан хаагчдын мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах, дадлага сургуулилт хийлгэх зорилгоор гадаад дотоодод сургалт, семинарт хамруулах болон эдгээр зорилгоор нэгдсэн семинар, сургалт, хурал зөвлөгөөн

ХААМСҮТ-д 2020 онд хичээл үйлдвэрлэлийн зардалд 12,008.0 сая төгрөгийн төсөв батлагдаж бүрэн зарцуулсан байна. 2020 оны хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын зарцуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Хүснэгт №4

| № | Үзүүлэлт              | Дүн      | Хувь  | Хичээл                                          |
|---|-----------------------|----------|-------|-------------------------------------------------|
|   | Материал /Дадлага /   | 5,874.5  | 48.6  | үйлдвэрлэлийн зардлын                           |
| 2 | Материал /Бусад/      | 1,490.0  | 12.3  | 58.6 хувь буюу 7,118.9                          |
| 3 | Интернэт              | 1,371.9  | 11.3  | мянган төгрөгийг хичээл                         |
| 4 | Шатахуун              | 1,303.5  | 10.8  | үйлдвэрлэлийн дадлага                           |
| 5 | Бичиг хэрэг           | 1,244.4  | 10.3  | хийх материал, бичиг                            |
| 6 | Сургалтын төлбөр      | 200.0    | 1.7   | хэргийн зардалд                                 |
| 7 | Тэмдэгтийн хураамж    | 343.8    | 2.8   | зарцуулсан, интернэт,                           |
| 8 | Цахим тоног төхөөрөмж | 260.0    | 2.2   | элсэлтийн шатахуун,                             |
|   |                       | 12,088.1 | 100.0 | тэмдэгтийн хураамж, цахим тоног төхөөрөмж зэрэг |

байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 4969.2 мянган төгрөгийг зориулалт бус зардалд зарцуулсан байна.

#### Аймаг дахь Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв

МСҮТ-д 2020 онд хичээл үйлдвэрлэлийн зардалд 26,450.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 26,365.4 мянган төгрөгийг зарцуулсан байна. 2020 оны хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын зарцуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. /Хүснэгт № 5 /

| № | Үзүүлэлт            | Дүн      | Хувь  | Хичээл                                 |
|---|---------------------|----------|-------|----------------------------------------|
| 1 | Материал /Дадлага / | 22,613.5 | 83.6  | үйлдвэрлэлийн дадлагын                 |
| 2 | Интернэт            | 958.3    | 3.6   | зардалд 83.6 хувь буюу                 |
| 3 | Сургалтын төлбөр    | 850.0    | 0.8   | 22,028.5 мянган төгрөг,                |
| 4 | Тэмдэгтийн хураамж  | 300.0    | 3.2   | интернэт, сургалтын төлбөр,            |
| 5 | Хөрөнгө бэлдсэн     | 1,743.6  | 8.8   | тэмдэгтийн хураамж,                    |
|   | Нийт дүн            | 26,365.4 | 100.0 | хөрөнгө бэлдсэн зэрэг байгууллагын үйл |

ажиллагаатай холбоотой 2,043.6 мянган төгрөгийг зориулалт бус зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5<sup>3</sup>, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалтай нийцэхгүй байна.

**Аймаг дахь МСҮТ** нь 2016 оны 11 дүгээр сарын 22 -ны багш нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, захирлын А/56 тоот тушаалаар баталсан МСҮТ-ийн танхимын болон үйлдвэрийн дадлага ажлыг зохион байгуулах журмын 3 дугаар зүйлийн 3.4 дэх “1-р курсийн үйлдвэр сургалтын хичээлээр дадлага хийх зардлыг зарлагдах, 2, 2.5 дугаар курс, 1 жилийн үйлдвэр сургалтын материалын зардлыг чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн агуулгаас хамааруулан 30-50 хувийг буцаан оруулна. Хугацаа, буцаан оруулах асуудлыг уян хатан шийдвэрлэнэ. Орлого тооцуулах хугацаа болон орлогын хувийг материалын захиалгат тусгаж өгнө” гэж

зохион байгуулахад шаардагдах сургалтын төлбөр, унаа хоолны зардал, сургалттай холбогдсон материал бэлтгэх, багшийн хөлс төлөх, сургалтын өрөө тасалгаа, тоног төхөөрөмж түрээслэх зэрэг зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Мөн бүх шатны боловсролын байгууллагуудын үзүүлэн таниулах материал, хичээлийн ба лабораторийн багаж, бодис худалдан авах, сургуулиудын хичээлийн байрандаа буюу хичээлийн байрнаас гадагш явж дадлага хийхтэй холбогдсон зардлыг энэ ангилалд бүртгэнэ”

<sup>3</sup> 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

заасан дагуу аймаг дахь МСҮТ нь 2020-2021 оны хичээлийн жилд анги, мэргэжил тус бүрээр хийж гүйцэтгэх бүтээлийг жагсаалтыг гаргаж байна.

Үүнээс оёмол бүтээгдэхүүний оёдолчин анги 6, гагнуурчин 5, бэлэг дурсгалын зүйл урлаачийн анги 12 нийт 23 бүтээгдэхүүнийг тус тус бэлтгэж өөрийн орлогод 275.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

## **БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ СУДАЛГАА ХИЙГДЭЭГҮЙ НЬ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫГ ЭРЭЛТТЭЙ МЭРГЭЖЛЭЭР ОЛГОЖ ЧАДАЖ БАЙГААГ ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ НӨХЦӨЛ БАЙДАЛД ХҮРГЭЖ БАЙНА.**

**2.1.1 Мэргэжлийн боловсрол олгох байгууллага нь зөвхөн суралцагчийн хэрэгцээ сонирхолд үндэслэн элсэлтийг зохион байгуулжээ.**

### **Аймгийн ХАА-н Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв**

Аймгийн ХААМСҮТ-д 2019-2020 оны хичээлийн жилд 2.5 жилийн сургалтад 1 мэргэжлээр 8 суралцагч, 1 жилийн сургалтад 9 мэргэжлээр 141 суралцагч, 2020-2021 оны хичээлийн жилд 2.5 жилийн сургалтад 1 мэргэжлээр /малын асаргаа/ 10, 1 жилийн сургалтад 9 мэргэжлээр 126 суралцагч элсүүлж сургалтын үйл ажиллагаа явуулжээ.

Аймгийн МСҮТ-ын 2019-2020, 2020-2021 оны хичээлийн жилд элсэгчдийн судалгаа

Хүснэгт №6

| № | Хичээлийн жил | Мэргэжлийн ангийн тоо | Элсэн суралцагчийн тоо | 2.5 жил суралцах /мэргэжлийн боловсрол олгох/ | 1 жил суралцах /мэргэжлийн сургалт/ | Түр сургалт |
|---|---------------|-----------------------|------------------------|-----------------------------------------------|-------------------------------------|-------------|
|   | 2019-2020     | 9                     | 149                    | 8                                             | 141                                 |             |
|   | 2020-2021     | 9                     | 136                    | 10                                            | 126                                 |             |

Хүснэгтээс харахад 2019-2020 оны хичээлийн жилд нийт элссэн суралцагчдын тоо 13-аар буюу өмнөх оноос 9 хувиар буурсан байна. Аудитын хамрах хугацаанд нийт элсэгчдийн 92.6 хувь нь 1 жилийн, 7.4 хувь нь 2.5 жилийн мэргэжлийн сургалтанд хамрагдсан байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-д “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх мэргэжлийн чиглэл, хяналтын тоо, элсэлтийн үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж зөвлөлийн шийдвэрийг үндэслэн энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллага батална.” гэж заасан байна.

Мэргэжил боловсрол, сургалтын аймгийн салбар зөвлөлийн 2020 оны 02 дугаар тогтоолоор 200 суралцагч элсүүлэхээр суралцагч элсүүлэх хяналтын тооны санал батлаж, ХНХЯ-д хүргүүлжээ.

ХНХ сайдын 2020 оны 05 дугаар сарын 26-ний өдрийн А/125 өдрийн тушаалаар 1 жилийн сургалтад 145, 2.5 жилийн сургалтад 75 суралцагч элсүүлэх хяналтын тоо батлаж ирүүлсэн байна.

ХНХС-ын баталсан элсэлтийн хяналтын тоог, элссэн суралцагчийн тоотой харьцуулж үзвэл

Хүснэгт № 7

| № | Индекс | Мэргэжлийн нэр | 2020-2021 оны хичээлийн жил |
|---|--------|----------------|-----------------------------|
|---|--------|----------------|-----------------------------|

|                 |    |         |                                            | Суралцагч<br>элсүүлэх<br>хяналтын тоо |           | Элссэн<br>суралцагч |          | Зөрүү (-+) |            |
|-----------------|----|---------|--------------------------------------------|---------------------------------------|-----------|---------------------|----------|------------|------------|
|                 |    |         |                                            | 1 жил                                 | 2.5 жил   | 1 жил               | 2.5 жил  | 1 жил      | 2.5 жил    |
| 1               | АТ | 7231-18 | Тракторын механик                          | 15                                    |           | 13                  |          | -2         | 0          |
| 2               | АФ | 6112-24 | Хүнсний ногооны фермер                     | 15                                    |           | 15                  |          | 0          | 0          |
| 3               | АФ | 6112-25 | Хүлэмжийн аж ахуйн фермер                  | 15                                    |           | 15                  |          | 0          | 0          |
| 4               | АФ | 6112-13 | Жимс, жимсгэнийн аж ахуйн фермер           | 15                                    |           | 14                  |          | -1         | 0          |
| 5               | АН | 6121-23 | Малын асаргаа                              | 15                                    | 25        | 14                  | 7        | -1         | -18        |
| 6               | НФ | 6210-21 | Ойжуулагч                                  | 15                                    | 25        | 11                  |          | -4         | -25        |
| 7               | ИФ | 7513-23 | Сүү боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан     | 40                                    |           | 30                  |          | -10        | 0          |
| 8               | АТ | 7231-20 | ХАА-н машин механизмын ашиглалт, засварчин |                                       | 25        |                     |          | 0          | -25        |
| 9               | АН | 6123-11 | Зөгийчин, зөгийн аж ахуй эрхлэгч           | 15                                    |           | 15                  |          | 0          | 0          |
| <b>Нийт дүн</b> |    |         |                                            | <b>145</b>                            | <b>75</b> | <b>127</b>          | <b>7</b> | <b>-18</b> | <b>-68</b> |

Дээрх хүснэгтээс элсэлтийн хяналтын тоотой харьцуулан үзэхэд 1 жилийн сургалтанд 145 хүүхэд элсүүлэхээс 127 буюу 87.5 хувь, 2.5 жил сургалтанд 75 суралцагч элсүүлэхээс 7 хүүхэд буюу 9.3 хувь байгаа нь 2.5 жилийн сургалтын элсэлтийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Түр сургалт явуулах тусгай зөвшөөрөлтэй ч ажил олгогчийн захиалга байхгүйтэй холбоотой сургалт явагдаагүй байна.

ХААМСҮТ-ийн захирлын 2020 оны 03 дугаар сарын 18-ны А/25 дугаар тушаалаар элсэлт зохион байгуулах ажлын хэсгийг 17 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулсан байна. Ажлын хэсэг нь элсэлт авахаар Булган аймгийн 5 сум, Хөвсгөл аймгийн 4 суманд ажиллахаар төлөвлөсөн ч хийсэн ажлын тайлан, хэдэн хүүхэд элсүүлсэн зэрэг материал байхгүй байна.

#### Аймаг дахь Мэргэжил сургалтын төв

Мэргэжил боловсрол, сургалтын Булган аймгийн салбар зөвлөлийн 2020 оны 02 дугаар тогтоолоор 405 суралцагч элсүүлэхээр суралцагч элсүүлэх хяналтын тооны санал батлаж, ХНХЯ-д хүргүүлжээ.

ХНХ сайдын 2020 оны 05 дугаар сарын 26-ний өдрийн А/125 өдрийн тушаалаар 1 жилийн сургалтад 240, 2.5 жилийн сургалтад 135 суралцагч элсүүлэх хяналтын тоо батлаж ирүүлсэн байна.

ХНХС-ын баталсан элсэлтийн хяналтын тоог,  
элссэн суралцагчийн тоотой харьцуулж үзвэл

Хүснэгт № 8

| № | Мэргэжлийн нэр | 2020-2021 оны хичээлийн жил |
|---|----------------|-----------------------------|
|---|----------------|-----------------------------|

|                 |                                                  | Суралцагч<br>элсүүлэх<br>хяналтын тоо |            | Элссэн<br>суралцагч |           | Зөрүү     |            |
|-----------------|--------------------------------------------------|---------------------------------------|------------|---------------------|-----------|-----------|------------|
|                 |                                                  | 1 жил                                 | 2.5 жил    | 1 жил               | 2.5 жил   | 1 жил     | 2.5 жил    |
| 1               | Авто машины засварчин                            | 15                                    | 15         | 19                  | 11        | 4         | -4         |
| 2               | Барилгын засал чимэглэл                          | 15                                    | 15         | 17                  |           | 2         | -15        |
| 3               | Барилгын сантехник                               | 15                                    | 15         |                     |           | -15       | -15        |
| 4               | Барилгын өрөг угсрагч                            | 15                                    |            |                     |           | -15       | 0          |
| 5               | Барилгын цахилгаанчин                            | 15                                    |            |                     |           | -15       | 0          |
| 6               | Гагнуурчин                                       | 15                                    | 15         | 20                  | 10        | 5         | -5         |
| 7               | Гоо засалч                                       | 15                                    | 15         | 21                  | 8         | 6         | -7         |
| 8               | Үсчин                                            | 15                                    |            | 25                  |           | 10        | 0          |
| 9               | Модон эдлэлийн мужаан                            | 15                                    |            | 17                  |           | 2         | 0          |
| 10              | НБД, АХажилтан                                   | 15                                    | 15         | 35                  |           | 20        | -15        |
| 11              | Цахим тоног төхөөрөмжийн<br>үйлчилгээний ажилтан | 15                                    |            | 20                  |           | 5         | 0          |
| 12              | Тогооч                                           | 15                                    | 15         | 41                  |           | 26        | -15        |
| 13              | Оёмол бүтээгдэхүүний<br>оёдолчин                 | 15                                    | 15         | 36                  |           | 21        | -15        |
| 14              | Худалдааны газрын                                | 15                                    |            |                     |           | -15       | 0          |
| 15              | Бэлэг дурсгалын зүйл<br>урлаач                   | 15                                    |            | 18                  |           | 3         | 0          |
| 16              | Тракторын механик                                | 15                                    | 15         | 19                  | 11        | 4         | -4         |
| <b>Нийт дүн</b> |                                                  | <b>240</b>                            | <b>135</b> | <b>288</b>          | <b>40</b> | <b>48</b> | <b>-95</b> |

/Эх сурвалж: ..... ХНХ сайдын тушаал /

Дээрх хүснэгтээс элсэлтийн хяналтын тоотой харьцуулан үзэхэд 1 жилийн сургалтанд 240 хүүхэд элсүүлэхээс 288 элсүүлж 48 хүүхэдээр илүү, 2.5 жил сургалтанд 135 суралцагч элсүүлэхээс 40 хүүхэд буюу 29.6 хувь байгаа нь 2.5 жилийн сургалтын элсэлтийг нэмэгдүүлэх, элсэлтийн хяналтын тоо батлах тухай тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

Аймгийн МСҮТ-үүд нь элсэлт зохион байгуулахдаа суралцагчдаас элсэн суралцах сонирхолтой мэргэжлийн ангийн судалгаа, тухайн мэргэжил нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэхэд судалгаа хийгдээгүй, ажил олгогчийн захиалгыг хэрхэн судалсан нь тодорхойгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн /төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх/ 30 дугаар зүйлийн 30.1.41 , 30.1.142 , Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т "... хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана" гэж заасан байна.

Үүнийг ХААМСҮТ-ийн сургуулийн сургалтын менежер, аймаг дахь МСҮТ-ийн НТХЗЗ хариуцсан мэргэжилтнээс тодруулахад "Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа байдаггүйгээс дээрх ажлууд хийгдэх боломжгүй байдаг" гэж тайлбарлаж байна.

Мөн аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгааны талаар аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн холбогдох мэргэжилтэн болон аймгийн ХХҮГ-ын удирдлагаас тодруулахад аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгаа байхгүй гэсэн тайлбарыг өгч байна.

Харин Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөрт "Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийж,

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн хөтөлбөр хэрэгжүүлж хүн амын ажилгүйдлийг бууруулах” гэсэн зорилтын хүрээнд тус судалгааг 2022 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөжээ.

Засгийн газрын 2016 оны 290 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол сургалтын үндэсний зөвлөлийн дүрмийн 3-д орон нутагт үндэсний зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэх салбар зөвлөлтэй байна гэж заасан байна. Үүний дагуу орон нутаг дахь салбар зөвлөл байгуулагдсан байх ба 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/55 дугаар тушаалаар 11 хүний бүрэлдэхүүтэй шинэчлэн баталсан ба зөвлөлийн дүрмийг 2010 оны 8 дугаар сарын 05-ний өдрийн хуралдааны 07 дугаар тогтоол МБСҮЗ-ийн хурлаар хэлэлцэн баталсан байна.

Салбар зөвлөл нь 2020 онд үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай, элсэлтийн хяналтын тооны санал хүргүүлэх тухай гэсэн 2 тогтоолоос өөр материал ирүүлээгүй, дүрмийн 3 дахь хэсэгт орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг үнэн зөв, бодитоор тогтоох, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ААНБ-ын мэргэжилтэй ажилтны захиалгыг судалж, шинээр элсүүлэх захиалгын саналыг мэргэжил бүрээр гарган мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад хүргүүлж хамтран ажиллана гэж тусгасан, гэтэл зөвлөлийн үйл ажиллагааг нотлох баримт материал байхгүй, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хэрхэн судалж, сургалтын байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллахаар дүрэмд тусгасан ч энэ талаар баримт материал байхгүй хийж хэрэгжүүлсэн ажил нь тодорхойгүй байгаа нь зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, үйл ажиллагааг идэвхижүүлэх шаардлагатай байна.

Мөн МСҮТ-ийн сургалтын менежерын албан тушаалын тодорхойлолтод заасан ажлын байрны чиг үүрэгт элсэлтийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, нийгмийн түншлэл хариуцсан ажилтны чиг үүрэгт хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа, сургалтын байгууллагын хүчин чадалд үндэслэн элсэлтийг зохион байгуулах зэрэг ажлууд тусгагдсан байгаа боловч хэрхэн хийгдсэн талаар баримт байхгүй, хийсэн ажил нотлогдохгүй байна.

Энэ нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1<sup>4</sup>-д, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4<sup>5</sup>-д мэргэжлийн боловсролыг олгох сургалтын элсэлтийг зохион байгуулах судалгааны ажил орхигдож, хуульд заасан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн захиалгад нийцсэн байх гэсэн үндсэн шаардлагын нэг хэсгийг хангахгүй байна.

### **2.1.2. Мэргэжлийн боловсрол олгох чиглэлийг бүрэн хэрэгжүүлээгүй, аймгийн хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй мэргэжил олгож байгаа эсэхийг тодорхойлох боломжгүй байна.**

ХААМСҮТ нь мэргэжлийн боловсрол олгох 11 чиглэлээр сургалт явуулах тусгай зөвшөөрөлтэй бөгөөд 2019-2020 онд 8, 2020-2021 оны хичээлийн жилд 7 мэргэжлээр суралцагч төгсгөсөн байна.

Сургалт явуулах тусгай зөвшөөрлөөс “Фермерийн аж ахуй эрхлэгч /ГТ-МАН/”, “ХАА-н машин механизмын ашиглалт, засварчин,” “Гэр ахуйн цахилгаан тоног төхөөрөмжийн засварчин” зэрэг мэргэжлээр элсэлт байхгүйтэй холбоотой сургалт явуулаагүй байна.


Аймгийн ХААМСҮТ-өөс 2019-2020, 2020-2021 оны хичээлийн жилд мэргэжлийн боловсрол, сургалтыг нийт 8 мэргэжлээр 245 суралцагч төгссөн байна.

<sup>4</sup> “Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх үүрэг бүхий байгууллага мөн”

<sup>5</sup> “суралцагч элсүүлэхэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэн зохион байгуулна ...”

Төгсөгчдийн тоо мэдээ

/Дүрслэл №2/



Мэргэжлийн боловсрол эзэмшсэн төгсөгчдөөс 2019-2020 оны хичээлийн жилд төгссөн 13 суралцагч, 2020-2021 оны хичээлийн жилд төгссөн 10 суралцагч дараагийн шатны сургуульд үргэлжлүүлэн суралцсан байна.

Аймгийн МСҮТ-ийг 2019-2020 оны хичээлийн жилд төгсөгчдийн мэргэжлийн судалгааг аймгийн ХХҮГ-аас ирүүлсэн тухайн жилийн ажил олгогчийн ажлын байрны захиалгатай харьцуулан үзэхэд дараах байдалтай байна.

**Ажлын байрны захиалгын тоог ХАА-н МСҮТ-ийг төгсөгчдийн тоотой харьцуулсан үзүүлэлт**

/Хүснэгт № 9/

| № | Мэргэжлийн нэр                             | 2019-2020 оны хичээлийн жил |                       |       |
|---|--------------------------------------------|-----------------------------|-----------------------|-------|
|   |                                            | Төгсөгчийн тоо              | Ажлын байрны захиалга | Зөрүү |
| 1 | Тракторын механик                          | 7                           | 1                     | 6     |
| 2 | Хүнсний ногооны фермер                     | 13                          | 3                     | 10    |
| 3 | Хүлэмжийн аж ахуйн фермер                  | 14                          |                       | 14    |
| 4 | Жимс, жимсгэнийн аж ахуйн фермер           | 13                          |                       | 13    |
| 5 | Малын асаргаа                              | 20                          | 25                    | -12   |
| 6 | Ойжуулагч                                  | 6                           | 1                     | 5     |
| 7 | Сүү боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан     | 31                          | 3                     | 22    |
| 8 | ХАА-н машин механизмын ашиглалт, засварчин | 7                           |                       | 15    |
| 9 | Зөгийчин, зөгийн аж ахуй эрхлэгч           |                             |                       | 0     |
|   | Нийт дүн                                   | 104                         | 33                    | 73    |

Судалгаанаас харахад зарим мэргэжилтэй ажилчдын ажлын байрны захиалга байхад зарим ажлын байрны захиалга огт байхгүй байна.

Тус сургуулийн сургалт явуулж байгаа мэргэжлийн чиглэлээс мал ажуй, малын эмч, малчны туслах ажлын байрны захиалга тодорхой хэмжээнд байна. Харин хүлэмжийн ах ахуйн фермер, жимсгэний аж ахуйн фермер, ХАА-н машин механизмын ашиглалт, засварчин гэсэн чиглэлээр ажлын байрны захиалга байхгүй байгаа талаар судлахад аймгийн хэмжээнд хувийн ААНБ нь цөөн, ихэвчлэн хувь хүн дангаар үйл ажиллагаа явуулдагтай холбоотой байна.

### Аймаг дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв

Тус МСҮТ нь мэргэжлийн боловсрол олгох 1 жилийн 17 мэргэжлээр сургалт явуулах тусгай зөвшөөрөлтэй бөгөөд 2019-2020 оны хичээлийн жилд 274, 2.5 жилийн 13 мэргэжлээр сургалт явуулах зөвшөөрөлтэй 2019-2020 оны хичээлийн жилд 3 мэргэжлээр 26 суралцагч төгсгөсөн байна.

Сургалт явуулах тусгай зөвшөөрлөөс авто машины засварчин, барилгын өрөгч угсрагч, засал чимэглэлч, сантехникч, цахилгаанчин, мужаан, захиалгын гуталчин зэрэг 7 мэргэжлийн боловсрол олгох сургалтыг элсэлт байхгүйтэй холбоотой явуулаагүй байна.

### Төгсөгчдийн тоо мэдээ

/Дүрслэл № 3/

|                              |                                                                                                                                  |
|------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 2019-2020 оны хичээлийн жилд | <ul style="list-style-type: none"> <li>1 жилийн 10 мэргэжлээр 274 төгсөгч</li> <li>2.5 жилийн 3 мэргэжлээр 26 төгсөгч</li> </ul> |
| 2020-2021 оны хичээлийн жил  | <ul style="list-style-type: none"> <li>1 жилийн 12 мэргэжлээр 275 төгсөгч</li> <li>2.5 жилийн 4 мэргэжлээр 32 төгсөгч</li> </ul> |

Мэргэжил сургалтын үйлдвэрлэлийн төвийг 2019-2020 оны хичээлийн жилд төгсөгчдийн мэргэжилийн судалгааг аймгийн ХХҮГ-аас ирүүлсэн тухай жилийн ажил олгогчийн ажлын байрны захиалгатай харьцуулан үзэхэд дараах байдалтай байна.

/Хүснэгт № 10/

| №  | Мэргэжлийн нэр                                | 2019-2020 оны хичээлийн жил |                       |       |
|----|-----------------------------------------------|-----------------------------|-----------------------|-------|
|    |                                               | Төгсөгчийн тоо              | Ажлын байрны захиалга | Зөрүү |
| 1  | Авто машины засварчин                         | 25                          | 7                     | 18    |
| 2  | Барилгын засал чимэглэл                       |                             | 6                     | -6    |
| 3  | Барилгын сантехник                            |                             | 4                     | -4    |
| 4  | Барилгын өрөг угсрагч                         |                             | 15                    | -15   |
| 5  | Барилгын цахилгаанчин                         |                             | 7                     | -7    |
| 6  | Гагнуурчин                                    | 55                          | 6                     | 49    |
| 7  | Гоо засалч                                    | 21                          | 0                     | 21    |
| 8  | Үсчин                                         | 20                          | 1                     | 19    |
| 9  | Модон эдлэлийн мужаан                         |                             | 6                     | -6    |
| 10 | НБД, АХажилтан                                | 33                          | 4                     | 29    |
| 11 | Цахим тоног төхөөрөмжийн үйлчилгээний ажилтан | 26                          | 1                     | 25    |

|    |                                  |     |     |    |
|----|----------------------------------|-----|-----|----|
| 12 | Тогооч                           | 34  | 40  | -6 |
| 13 | Оёмол бүтээгдэхүүний оёдолчин    | 35  | 3   | 32 |
| 14 | Худалдааны газрын үндсэн ажилтан | 19  | 9   | 10 |
| 15 | Тракторын механик                | 32  | 1   | 31 |
|    | Нийт дүн                         | 300 | 110 |    |

Хүснэгтээс үзэхэд тухайн жилийн онцлогоос хамааран зарим мэргэжилтэй ажилчдын ажлын байрны захиалга байхад зарим ажлын байрны захиалга огт байхгүй байна. Тухайлбал уул уурхай, барилгын компаний үйл ажиллагаа идэвхитэй байх эсэхээс шалтгаалан тухай мэргэжлийн ажилтан болон тогоочийн ажлын байрны захиалга их байна. Харин Гагнуурчин, Гоо засалч, оёмол бүтээгдэхүүний оёдолчин, тракторын механик ажлын байрны захиалга байхгүй байгаа талаар судлахад аймгийн хэмжээнд хувийн ААНБ нь цөөн, ихэвчлэн хувь хүн дангаар үйл ажиллагаа явуулдагтай холбоотой байна.


Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн судалгаа байхгүй учир зөвхөн аймгийн ХХҮГ-т бүртгэлтэй ажлын байрны захиалгаар эрэлт хэрэгцээг бүрэн тодорхойлох боломжгүй байна.

**Үйл ажиллагааны бодит үр дүн буюу төгсөгчдийн ажил эрхлэлтэд анхаарах шаардлагатай байна.**

Суралцагчдыг төгссөнөөс хойших 3,6,12 дахь саруудад ажил эрхлэлтийн мөшгөх судалгааг хийдэг ба 2019-2020 оны хичээлийн жилд төгссөн сурагчдаас ХААМСҮТ 1, аймаг дахь МСҮТ 2 удаа судалгааг авсан байна.

Төгсөгчдын ажлын эрхлэлтэд хийсэн мөшгөх судалгааг графикаар харуулбал

Дүрслэл № 4



Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 25.0-27.0 хувь нь мэргэжлийн бус ажил эрхлэж, 13- 27.0 хувь нь ажлын байраар хангагдаагүй байна.

Ажилгүй байгаа төгсөгчдын шалтгааныг хийсэн судалгаанаас үзэхэд тухайн эзэмшсэн мэргэжлийн чиглэлийн ажлын байр, үйлдвэрлэл аймаг орон нутагт хомс, олдохгүй байгаа, өрхийн аж ахуй эрхлэлтэнд дэмжлэг хангалтгүй, коронавируст цар тахал нь ажлын байр хайх боломжийг хязгаарласны зэрэгцээ цэцэрлэгт насны хязгаарлалт тогтоож хүүхэд авч байгаа учир хүүхдээ харах шаардлага үүссэнтэй холбон тайлбарлаж байна.

Судалгаанд хамрагсад мэргэжлийн ангид элсэн орохдоо ажлын байрны хангалттай байдлын талаар судлаагүй, зөвхөн өөрийн сонирхлоор элсэн суралцсан байдал нь төгсөөд гарахад мэргэжлийн ажил олдохгүй байх эрсдэлийг бий болгож байна. Ажилгүй байгаа төгсөгчдийн мэргэжлийн авч үзэхэд тракторын механик, жимс, жимсгэний аж ахуйн фермер, сүү боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан, нарийн бичгийн дарга, архивын ажилтан, гагнуурчин мэргэжлээр илүүтэй байна.

Нийгмийн түншлэл, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, статистик хариуцсан мэргэжилтэний ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгт төгсөгчдийг түншлэгч байгууллагуудын ажлын байранд зуучлах ажлыг зохион байгуулах, төгсөгчдийн ажлын байран дээрх ур чадварын үнэлгээг хийх зэрэг ажлууд тусгагдсан байгаа боловч хэрхэн хийгдсэн талаар баримт байхгүй, мөн төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдалд мөшгих судалгааг хийж нэгтгэн холбогдох дээд байгууллагад хүргүүлэх төдий л байна.

Судалгааг үр дүнтэй бодиттой хийх, гарсан үр дүнд, дүн шинжилгээ хийж үйл ажиллагаандаа ашиглах шаардлагатай байна.

Мөн МБСҮЗ-ийн орон нутгийн салбар зөвлөлийн хэрэгжүүлэх чиг үүрэгт төгсөгчдийг ажлын байртай холбоход шууд дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэгтэй гэж заасан байна. Гэтэл энэ талаар зохион байгуулсан ажлын баримт материал, холбогдох нотлох баримт байхгүй, үйл ажиллагаагаа хэрхэн явуулдаг нь тодорхойгүй байна.

## **2.2.1 БУЛГАН АЙМАГ ДАХЬ МСҮТ-ҮҮДЫН ДОТООД ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

Булган аймагт үйл ажиллагаа явуулж буй мэргэжил сургалт үйлдвэрийн төвүүдийн бүтэц орон тооны дагуу хяналт шинжилгээ, мониторинг хариуцсан ахлах мэргэжилтэн тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Ажилтны албан тушаалын тодорхойлолтын чиг үүрэгт байгууллагын дотоод аудитыг хэрэгжүүлэхээс гадна мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргасан байна гэж тусгасан байна.

Аймаг дахь МСҮТ, ХААМСҮТ-үүд нь дотоод хяналтын үйл ажиллагаандаа Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг тус тус баримтлан ажиллаж байна.

Мэргэжил сургалт үйлдвэрийн төвүүд нь 2020-2021 оны хичээлийн жилд дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд тус бүр 28 ажил хийхээр батлуулсан байна.

2020-2021 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал

/Хүснэгт № 11 /

| Д/д | Байгууллагын нэрс      | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөөт бус | Хэрэгжилтийн хувь |
|-----|------------------------|------------|-----------|-----------------|-------------------|
| 1   | Булган аймаг дахь МСҮТ | 28         | 3         | 0               | 10.7              |
| 2   | Булган аймгийн ХААМСҮТ | 28         | 6         | 8               | 21.4              |

Хүснэгтээс үзэхэд мэргэжил сургалт үйлдвэрийн төвүүдийн дотоод хяналт шалгалтын гүйцэтгэл нь 10.7-21.4 хувтай байна.

Аймаг дахь МСҮТ төв нь 2020 онд сургалтын албаны ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагаа, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилт, багш ажилтнуудын цалин урамшуулал олгосон баримт, няравын анхан шатны бүртгэл хөтлөлт, бусад баримт бичгийн хөтлөлтөд зэрэг 3 удаагийн хяналт шалгалтыг хийж төлөвлөсөн ажлын 10.7 хувийг гүйцэтгэсэн байна.

ХААМСҮТ-ийн хувьд 2020 онд төлөвлөгөөт бус 8, төлөвлөгөөт 6 удаагийн хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна. Үүнд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2, байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 2, байгууллагын дотоод зөвлөл, комиссын үйл ажиллагаа, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт хийж төлөвлөгөөний биелэлт 21.4 хувьтай байгаа нь МСҮТ-үүдийн дотоод хяналт шалгалт хангалтгүй байгааг харуулж байна.

Харин мэргэжлийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ огт хийгдээгүй байгаа нь хяналт шалгалтыг оновчтой үр дүнтэй гүйцэтгэх, төлөвлөсөн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна.**

Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1<sup>6</sup>-д тус хуулийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хяналтыг тавина гэж заасан байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2020 онд мэргэжлийн боловсрол сургалтын үйл ажиллагаа, элсэлтийг хэрхэн авч байгаа, төгсөгчид ажлын байраар хангагдсан эсэх, сургалт явуулах үйл ажиллагаа нь хуулийн зорилго зорилтыг хангаж чадаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийгдээгүй байна.

**ХААМСҮТ-өөс ирүүлсэн саналд Булган аймаг дахь Төрийн аудитын газраас дараах тайлбарыг өгч байна.**

| Үзүүлэлт  | Тайлбар                                                     |
|-----------|-------------------------------------------------------------|
| Тайлбар 1 | Санал биш тайлбар ирүүлсэн тул хүлээн авах боломжгүй байна. |
| Тайлбар 2 | Санал биш тайлбар ирүүлсэн тул хүлээн авах боломжгүй байна. |
| Тайлбар 3 | Санал биш тайлбар ирүүлсэн тул хүлээн авах боломжгүй байна. |
| Тайлбар 4 | Санал биш тайлбар ирүүлсэн тул хүлээн авах боломжгүй байна. |

## ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- ✚ Мэргэжлийн боловсрол, сургалтыг олгох боловсон хүчнээр хангагдсан байна.
- ✚ Мэргэжлийн боловсролыг олгох сургалтын элсэлтийг зохион байгуулах судалгааны ажил орхигдож, хуульд заасан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн захиалгад нийцсэн байх гэсэн үндсэн шаардлагын нэг хэсгийг хангахгүй байна.
- ✚ Үйл ажиллагааны бодит үр дүн буюу төгсөгчдийн ажил эрхлэлтэнд анхаарах шаардлагатай байна.
- ✚ Хичээл үйлдвэрлэлийн зардлаас зориулалт бус зардал гаргасан байна.
- ✚ Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн судалгаа байхгүй учир зөвхөн аймгийн ХХҮГ-т бүртгэлтэй ажлын байрны захиалгаар эрэлт хэрэгцээг тодорхойлоход хүрч байна.
- ✚ Үйл ажиллагаанд хийж буй дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байна.

<sup>6</sup> 26.1-д "Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавина."

### **ЗӨВЛӨМЖ:**

**Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:**

#### **МЭРГЭЖИЛ СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ Ч.ОЮУНТУЯА, Н.ПҮРЭВСАЙХАН НАРТ**

- ✓ МСҮТ-үүд нь ХНХС-ын баталсан бүтэц, орон тоог баримталж ажиллах.
- ✓ Элсэлт зохион байгуулахдаа суралцагчдаас элсэн суралцах сонирхолтой мэргэжлийн ангийн судалгаа, тухайн мэргэжил нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэхэд судалгаа хийж, ажил олгогчийн захиалгыг үндэслэн зохион байгуулах гэсэн чиг үүргийг хэрэгжүүлэх.
- ✓ Төгсөгчдийн ажлын байрны дэлгэрэнгүй судалгааг үнэн зөв гаргаж тайлагнах, ажлын байрны хангалтад дотоод, гадаад орчны шинжилгээг хийж үйл ажиллагаандаа ашиглах.
- ✓ Хичээл үйлдвэрлэлийн зардлыг зориулалтын дагуу зарцуулах.
- ✓ Дотоод хяналтыг оновчтой үр дүнтэй гүйцэтгэж, үр нөлөөг сайжруулах.

#### **МЭРГЭЖИЛ БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БУЛГАН АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Д.ЖАРГАЛСАЙХАНД**

- ✓ Мэргэжил боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн дүрэмд орон нутагт шаардлагатай мэргэжилтэй ажилчдын эрэлт хэрэгцээг үнэн зөв, бодитоор тогтоох, ААНБ-ын захиалгыг судалж шинээр элсүүлэх захиалгын саналыг мэргэжил бүрээр гарган МСҮТ-тэй хамтран ажиллах, төгссөн суралцагчдыг ажлын байртай болоход дэмжлэг үзүүлэх гэсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 01/24

Булган

Аудитын тайлан  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/27 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө", 2018 оны А/221 дүгээр тушаалаар баталсан "Аудитын чанарын хяналтын журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний дагуу "Аймгийн МСҮТ-үүдийн үйл ажиллагаа, хууль, журмын хэрэгжилтийн үр дүн"-д хийсэн нийцлийн аудитын тайлан, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
2. Нийцлийн аудитын тайланг Булган аймаг дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт үйлдвэрийн төвийн захирал нарт хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг мэргэжил сургалт үйлдвэрийн төвийн захирал нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь хангуулж, биелэлтийг тооцон хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ж.Энхцоодол/-т даалгасугай.
5. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, Төрийн аудитын байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд түгээхийг ахлах аудитор /П.Содном/-д үүрэг болгосугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ДАНХБАЯР